



MONGOLIAN WOOL & CASHMERE
ASSOCIATION

МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН БИЗНЕСИЙН ОРЧИН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ

2025



АГУУЛГА

- МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН ХОЛБООНЫ ТАНИЛЦУУЛГА
- МОНГОЛ УЛСЫН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО
- САЛБАРЫН СТРАТЕГИ
- МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН САЛБАРЫН ЭКСПОРТЫН БОЛОМЖ
- МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН САЛБАРТ ХЭРЭГТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**МОНГОЛЫН НООЛУУРЫН
САЛБАРЫН БИЗНЕСИЙН
ОРЧИН, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ**

МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН ХОЛБОО НҮТББ

БАЙГУУЛАГДСАН ОН:

1993

**НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА**

ГИШҮҮНЧЛЭЛ:

154

АЛСЫН ХАРАА:

**ДЭЛХИЙД БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ, НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГАТАЙ, ХҮНИЙ ЭРХИЙГ
ДЭЭДЭЛСЭН, ТОГТВОРТОЙ ТЕКСТИЛИЙН
ҮЙЛДВЭРЛЭГЧ ОРОН БОЛНО.**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Хууль эрх зүй, татварын орчин
- Чанар, стандартын баталгаажуулалт
- Сургалтын төв
- Текстилийн технологийн төв
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, маркетинг

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС:

- Монгол ноос, ноолуур
- Харилцан итгэлцэл
- Мэргэшсэн боловсон хүчин
- Олон талт идэвхитэй оролцоо
- Инноваци, дэвшилтэт техник технологи



ЧАНАР, СТАНДАРТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Бүтээгдэхүүн Монгол улсын
MNS стандарттай нийцсэн эсэх



ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ

Стандартчилал, техникийн
зохицуулалт тохирлын үнэлгээ,
итгэмжлэлийн тухай хуулийн
13,3-д заасан угаасан ноос,
самнасан ноолууран
бүтээгдэхүүн Засгийн газрын 291
тоот тушаалаар заавал
баталгаажуулалтад хамруулах...



МОНГОЛЫН ХААН ШИРХЭГТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАРЫН СТАНДАРТ

Бүтээгдэхүүний чанарын
үзүүлэлт

- Будгийн тогтвор
- Хэмжээний тогтвортой байдал
- Ноолуур агууламж
- онголын гарал үүсэлтэй түүхий эд



ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТ

- Байгалийн нөөцийн зохистой хэрэглээ
- Нийгмийн хариуцлага
- Үйлдвэрлэлийн хог хаягдал
- Хүн, байгальд хор нөлөөгүй
- Эрчим хүчний болон химийн бодисын хэрэглээ
- Хөдөлмөр хамгаалал, мал амьтны эрх



ГАЗАР ЗҮЙН ЗААЛТ /GI/

“Газар зүйн заалт” гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэр/

- Цагаан
- Цайвар
- Хөх саарал
- Бор
- Хар бараан



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ



ЭДИЙН ЗАСАГ



БҮС, ОРОН
НУТГИЙН ХӨГЖИЛ



НОГООН ХӨГЖИЛ

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж,
экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах
үйлдвэрлэлийг байгальд ээлтэйгээр хөгжүүлэх, түүхий
эдийн боловсруулалтын түвшнийг ахиулах, нэмүү өртөг
шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг
нэмэгдүүлэх.



ЦАГААН АЛТ

2023 он - Ноолуурын бүрэн боловсруулалтын
түвшнийг **20%-иас**

2028 онд **40%** хүртэл нэмэгдүүлнэ.

42ком - 320,7 тэрбум.төг

12ком- 25,6 тэрбум.төг

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

БООМТЫН СЭРГЭЛТ

Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг
хөгжүүлэн ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг
дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

САЛБАРТ ХАМААРАХ: 1 ЗААЛТ

АЖ ҮЙЛДВЭРИЙН СЭРГЭЛТ

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт
техник, технологид тулгуурлан хөгжүүлж, шинэ
бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн
хэмжээг нэмэгдүүлнэ.

САЛБАРТ ХАМААРАХ: 8 ЗААЛТ

ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

Улаанбаатар хотоос орон нутагт шилжин
суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц
бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна

САЛБАРТ ХАМААРАХ: 5 ЗААЛТ

НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь
нэмэр оруулах зорилгоор "Тэрбум мод" үндэсний
хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн
нэгж бэйгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ

ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

Стратегийн зорилт 1:

Салбарын өргөжин тэлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжих бизнесийн экосистемийг хөгжүүлэх

- 1.1: Салбарын нэгдэл, уялдаа холбоог сайжруулахын тулд оролцогч талуудын сүлжээг идэвхижүүлэх
- 1.2: Салбарын шинэчлэл, үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн шийдлийг хэрэгжүүлэх
- 1.3: Олон улсад үр дүнтэй өрсөлдөхийн тулд хөрөнгө оруулалтыг дэмжих

Стратегийн зорилт 2:

Нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн чадавхыг сайжруулах

- 2.1 Нөөцийн ашиглалтыг оновчтой болгохын тулд малчин, мал аж ахуйн тогтвортой менежментийг сурталчилах
- 2.2 Өртгийн сүлжээний дагуу ажиллах чадвартай боловсон хүчин, үйлдвэрлэлийн чадавхийг ахиулах
- 2.3 Ноос, ноолуурын салбарт судалгаа, хөгжүүлэлт хийх институцийн тогтолцоог төлөвшүүлэх

Стратегийн зорилт 3:


Экспорт хийх зорилтот улсуудтай зах зээлийн холбоо харилцааг бэхжүүлэх

- 3.1: Экспортын зах зээлд бүтээгдэхүүний техникийн шаардлага, стандартад нийцүүлэх боломжийг бүрдүүлэх
- 3.2: Экспортод гарахад бэлэн бизнесүүдийн экспортын маркетингийн чадавхийг бэхжүүлэх
- 3.3: Монголын ноос ноолуурын бүтээгдэхүүнийг сурталчилах, брэнд бүтээх

НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, АЖИЛЛАХ ХҮЧИН



Нийт үйлдвэрлэлт 2024 онд
409.6 сая ам.долл



САМНАСАН НООЛУУРЫН ЭКСПОРТ
/2019-2025/



2024 – 2025 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН БАЙДЛААР

	САМНАСАН НООЛУУР		ЭЦСИЙН БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮН	
	Тоо хэмжээ /тн/	Үнийн дүн /сая.дол/	Тоо хэмжээ /мян/шир/	Үнийн дүн /сая.дол/
2024	471,8тн	46,0	82,734	6,5
	↓ x5		↓ 16%	
2025	2304,6тн	188.0	95,763	7,6

Тайлбар:

- Самнасан ноолуурын экспорт эхний 9 сарын байдлаар тоо хэмжээ **5 дахин**, үнийн дүнгээр **4,1 дахин** өссөн.
- Эцсийн бэлэн бүтээгдэхүүн эхний 8 сарын байдлаар **16 хувийн** өсөлттэй байсан бол 9 сард 2,7 хувь буурсан.



- 2025 оны 2 сараас угаасан ноолуурын экспортыг хориглосон нь боловсруулсан ноолуурын эрэлт гадаад зах зээлд нэмэгдэж байна.
- Хэрэглэгчийн худалдан авах зан төлөв байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг эрхэмлэснээр экспорт өсч байна.
- Евроазийн хэлэлцээрийн хүрээнд 2026 оны 01 сарын 01-нээс хойд хөршрүү 204 нэр төрлийн ноос ноолууран бүтээгдэхүүн гаалийн татваргүй орох боломж бүрдэж байна.
- Хөнгөлөлтийн ерөнхий систем буюу GSP+-ийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэг.
- Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд 5700 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж байна.
- Ноолуурын эрэлт дэлхийн хэмжээнд ялангуяа Европт нэмэгдэж байна.
- Хятадын зах зээл 100,0 сая ширхэг ноолууран бүтээгдэхүүн импортоор авсан нь урд хөршийн зах зээлд боломж байгааг харуулж байна.
- АНУ-ын зах зээлд Монгол ноолуурыг сурталчилан таниулсанаар зах зээлд эрэлт хэрэгцээ тогтмол өсч байна.
- Монгол Улсаас санаачлан боловсруулсан ISO стандарт нь текстил, мал амьтны тавлаг байдал, ноолуур бэлтгэх, шошголох, үйлдвэрлэх, мөшгөх тогтолцоонд тавигдах шаардлага олон улсын стандартчилалын байгууллагын техникийн хороогоор дэмжигдэж батлагдлаа.



Шаардлагатай хөрөнгө оруулалт	Үндэслэл
Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах /Түүхий эдийн сан/ Мөшгөх тогтолцоог хөгжүүлэх	Ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог хөгжүүлэх, нэмүү өртгийн сүлжээний тогтвортой байдлыг хангахад түүхий эд бэлтгэгч малчид, малчдын хоршоодыг чадавхижуулах, ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний мөшгөх тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ үүсээд байна. Хэрхэн? Малын эрүүл мэнд, тавлаг байдал, бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадварын талаарх мэдээ мэдээлэл сургалтыг зохион байгуулах, өртгийн сүлжээг бүхэлд нь мөшгөх тогтолцоог олон улсын стандарт, дүрэм, журамд нийцүүлэн сайжруулах, нөөцийн ашиглалтыг оновчтой болгох, малын тавлаг байдал, биологийн олон янз байдлыг хамгаалах хүчин чармайлтыг сайжруулах, малчид малчдын хоршоодыг үндэсний үйлдвэрлэгчидтэй холбох дижитал сургалт, онлайн платформ хөгжүүлэх Санхүүжилтийн эх үүсвэр: Төсөв, донор байгууллага
Ноолуурын салбарын суурилагдсан хүчин чадал, ээрэх үйлдвэрлэлд	Ноос ноолуурын салбарын гүн боловсруулалт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн суурилагдсан ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх, өндөр техник, технологи тоног төхөөрөмжийг шинэчлэл, сайжруулалтыг хийх шаардлагатай. Хэрхэн? Ээрэх үйлдвэрлэлд анхаарлаа хандуулах ээрэх салбарын хэрэгцээг тодорхойлохын тулд салбарын оролцогч талуудын хооронд илүү нягт уялдаа холбоог бий болгох, урамшуулал, санхүүгийн схем эсвэл бага хүүтэй урт хугацааны зээл олгох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг/ГШХО/ дэмжих, хамтарсан үйлдвэр байгуулах Санхүүжилтийн эх үүсвэр: Төсөв, хувийн, гадаадын шууд хөрөнгө оруулалт
Боловсруулах компаниудын технологийн шинэчлэл	Салбарт шинэчлэлт хийх замаар экспортлоход бэлэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үр ашигтай үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн хаягдлыг бууруулах, дахин боловсруулах техник технологийг эзэмших, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг сурталчилгааг тогтмол хийх шаардлагатай байна. Хэрхэн? Үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмж, удирдлагын систем зэрэг технологи, дэд бүтцийг шинэчлэхэд оролцогч талуудыг дэмжих. Урамшуулал эсвэл санхүүгийн схемээр хангах, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийн шийдэл, дэлхий нийтийн туршлагын талаар мэдээ, мэдээлэл өгөх, чадавхижуулах, сургалт семинарыг тогтмол зохион байгуулах Санхүүжилтийн эх үүсвэр: Төсөв, хувийн, гадаадын хөрөнгө оруулалт
Салбарын хүний нөөцийг чадавхижуулах	Салбарын нэмүү өртөг шингээх, дижитал шилжилт, өндөр техник технологид зориулан ажиллах хүчний мэдлэг, ур чадварын чадавхийг тасралтгүй дээшлүүлэх, уялдаа холбоо бүхий бодлогын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрхэн? Эмэгтэй ажилчдын ур чадвар ахиулах, ахисан түвшний удирдлагуудын менежментед бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх, Итали Монголын инеженер техникийн ажилтан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, хоёр улсын их дээд сургууль хоорондох дипломын хөтөлбөрийг санаачлах, дэлхийн тэргүүлэх инженерийн коллеж, дизайны институтууд болон/эсвэл академич нартай зөвшилцөн сургалтын хөтөлбөр боловсруулж, багш нарыг хөгжүүлэх, МННХ-ны дэргэдэх текстилийн технологийн төвийг чадавхижуулах хүрээнд лаборатори, туршилт судалгаа, инноваци хөгжүүлэлтийн Төв болгон өргөжүүлэх Санхүүжилтийн эх үүсвэр: Төсөв, донорын санхүүжилт

АНХААРЛХАНДУУЛСАНД БАЯРЛАГАА